

МОНГОЛ ДАХЬ БУДДЫН СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН ҮНЭ ЦЭН, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ

О.Бумдарь, доктор (Ph.D)

МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн багш

С.Янжинсүрэн, доктор (Ph.D), профессор

МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн багш

Товч утга: Буддын шашин Монгол нутагт, нүүдэлчдийн соёлын хөрсөнд гурвантаа дэлгэрэн хөгжихдөө Монголын онцлог бүхий буддын соёлыг бүтээж, монголчуудын соёлын өвийн сан хөмрөгт томоохон орон зай эзлэх болсон. Тиймээс Монгол Улс дахь буддын соёлын өвийг бүртгэх, хадгалах, хамгаалах, судлах ажил нь Монгол дахь соёлын өвийн судалгааны салшгүй чухал хэсэг юм.

Соёлын салбарын мэргэжлийн байгууллагуудын судалгаа, тайлан, дүн мэдээнд Монгол дахь буддын соёлын биет өв, түүний хадгалалт, хамгаалалтын талаарх мэдээлэл байдаг боловч тэдгээрийг нэгтгэн дүгнэж, судалж танилцуулсан нь хомс юм. Тиймээс бид тус өгүүлэлд Соёлын Өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэлтэй буддын соёлын биет өвийн мэдээлэлд шинжилгээ хийв. Мөн Монгол дахь буддын соёлын биет өвийн үнэлэмж, үнэ цэнийг тогтоох, сэргээн засварлалт, хадгалалт, хамгаалалтын талаар хэрэгжүүлж ирсэн төрийн бодлогыг улируулан авч үзэв.

Түлхүүр үг: Буддын соёлын биет өв, түүх, соёлын дурсгал, сүм хийд, хадгалалт, хамгаалалт

Удиртгал

Бурханы шашин Монгол оронд гурвантаа дэлгэрсэн хэмээн Хор чойнжун буюу буддын шашны түүхийн зохиолуудад өгүүлдэг. Бурханы шашин Монголд дэлгэрэх бүртээ тухайн үеийнхээ “нийгэм, соёл, эдийн засаг, оюун санааны байдалтай холбоотойгоор өөр өөрийн өнгө төрхийг хадгалж хөгжжээ”.¹ Энэхүү түүхэн үйл явц дунд бурханы шашин нь монголчуудын түүх, соёл, ахуй амьдралын салшгүй хэсэг болон хөгжиж, Буддын мэдлэг ухаан нь Монголчуудын төрт ёс, урлаг, соёл боловсрол, философи сэтгэлгээнд гүнзгий нөлөө үзүүлсэн юм.

XIX зууны сүүлч, XX зууны эхэн үе болоход Монголд Бурханы шашин нэн өргөн хүрээг хамарч хөгжжээ. Үүний нэг баримт нь Монголчуудын бүтээн байгуулсан сүм хийдийн цогцолборууд юм.

“XX зууны эхэн үеийн байдлаар Монголд 2960 тооны сүм, дуган бүхий 790 орчим хүрээ хийд, хурлын газрууд байсан бөгөөд тэнд 100.000 гаруй лам хуврагууд шавилан сууж байжээ”.² Хүрээ хийдүүд соёл боловсролын төв болж, буддын дүрслэх урлаг эрчимтэй хөгжин, дуган сүмүүд нь буддын уран барилгын сонгодог дурсгалууд болсны сацуу тэдгээрт түүх, соёлын хосгүй үнэт дурсгалууд хуримтлагдсан байна. Монгол дахь Буддын мэдлэг ухааны хөгжлийн явцад Монголчууд буддын соёлын биет болон биет бус арвин их өв санг буй болгосон юм.

Монголд дэлгэрсэн Бурханы шашин мандаж, буурсан ээдрээт түүхийг туулсан. XX зууны эхний хагаст Большевикууд Монголд хэрэгжүүлсэн шашныг устгах бодлогоороо монголчуудын хэдэн зууны туршид туурвин бүтээж, үеэс үед уламжлуулан хөгжүүлсэн соёлын

¹ Г.Лувсанцэрэн, Э.Ариунаа. Буддын уламжлалт мэдлэг ухааны үндэс. УБ., 2007, тал 26.

² Н.Хатанбаатар. Монголын хүрээ хийд, лам нар. (XVI-XX зууны жэн). УБ., 2018, тал 5.

үлэмж их өвийг сүйтгэж, олон зуун сүм хийдийг устган, эрдэмтэй лам нарыг хэлмэгдүүлсэн нь Монгол үндэстэнд нөхөж баршгүй хохирол болсон юм. 1937 оны эхээр Монголд нийт 771 тооны сүм хийд, хурал мөргөлийн газар байсан бол 1938 оны 8 сар гэхэд 760-ыг нь бүрэн устгаж³ дуусгасан буюу улс нийгмийн хөрөнгө болгон шилжүүлсэн байна.⁴ Үүнээс хойш 1944 оны зун Улаанбаатарт өнөөгийн Гандантэгчэнлин хийд мөргөлийн ганц дугантайгаар нээгдэх хүртэл Монгол улс 6 жилийн турш ганц ч сүм дугангүй байсан⁵ гашуун түүхийг туулсан байдаг. Хэдийгээр хэлмэгдүүлэлтийн жилүүдэд Бурханы шашны түүх, соёлын үлэмж их дурсгалуудыг устгасан ч “их савны ёроол хоосордоггүй”-н үлгэрээр нэлээд хэмжээний соёлын өв өнөөдрийг хүрч ирсэн нь нэн сайшаалтай.

1. Дэлхийд үнэлэгдсэн Монголын Бурханы шашны соёлын биет өв

1990 оноос шашин шүтлэгээ сэргээж, социализмын үед хаагдмал байсан бурханы шашнаа судалж хөгжүүлэх, сүм дуган барьж босгох зэрэг үйл ажиллагаа Монгол орон даяар өрнөсөн юм. Өнөөдөр Монголд сэргээн засварласан болон шинээр барьж байгуулан, тогтмол үйл ажиллагаагаа явуулж буй Бурханы шашны сүм хийдийн тоо 150-д⁶ хүрчээ.

Эдүгээ Монголын төрөөс Монголчуудын зан заншил, соёл уламжлалд гүн шингэсэн уламжлалт Бурханы шашны өв соёлыг хадгалах, сэргээн хөгжүүлэх бодлогыг баримталж, түүнийгээ хууль, эрх зүй, бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлж буй. Тухайлбал, “Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл баримтлал”-ын Соёл иргэншлийн аюулгүй байдлын тухай хэсгийн 3.1.4.8-д “Монголын ард

түмний олон зуун жилийн оюуны өвийг тээж, хадгалж ирсэн Монголын Бурхны шашны өв соёлын судалгааг төрөөс онцлон дэмжинэ”. “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн 2 дугаар бүлгийн 5.1.6-д зааснаар өмчийн хэлбэр харгалзахгүйгээр “эртний хот суурин, сүм хийдийн үлдэгдэл, түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгал”-ыг түүх, соёлын үл хөдлөх дурсгалд, 6.1.11-д “уламжлалт шашин, шүтлэгийн холбогдолтой эд өлгийн зүйл”-ийг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлд тус тус хамруулахыг, мөн хуулийн 7.1.13-д “уламжлалт шашин, шүтлэгийн зан үйл, ёс заншил”-ыг соёлын биет бус өв болохыг тодорхойлсон байна. “Уламжлалт шашин” хэмээн тодорхойлсон хуулийн эдгээр заалтууд нь төрөөс Бурханы шашны монголын түүх, соёл, шинжлэх ухаан, соёлын өвийн үнэ цэнийг тал бүрээр үнэлсний үндсэн дээр түүнийг хадгалах, хамгаалах, өвлөн уламжлахын зайлшгүй болохыг хуульчилсан хэрэг мөн болно.

Монголчуудын бүтээсэн буддын соёлын дурсгалууд нь өнөөдөр монголын төдийгүй дэлхийн хэмжээний үнэ цэнтэй дурсгалд тооцогдож байна. 1992 оноос ЮНЕСКО-ийн “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн хүрээнд дэлхийн улс орнуудын баримтат өвийн ховор хосгүй дурсгалуудыг “Дэлхийн Баримтат өвийн жагсаалт”-д бүртгэн тунхаглах болсон.⁷ Баримтат өвийн Олон улсын болон Бүс нутгийн бүртгэлийн жагсаалтад өнөөдрийн байдлаар 110 орны 350 гаруй баримтат өв бүртгэгдээд байна.⁸

Монгол улс баримтат өвийн баялаг өв сантайн тодорхой илрэл бол Монгол Улсын Үндэсний номын сангийн “Монгол судлал, гар бичмэл номын сан хөмрөг”-т 21 мянга орчим гар бичмэл, барын ном, “Төвөд номын сан хөмрөг”-т монгол, төвөд

³ МУУТА, УТНОНБ-ын архив. Х-4, Д-6, ХН-92. тал 337.

⁴ О.Батсайхан, З.Лонжид, С.Баатар. Хэлмэгдэл ба Цагаатгал: түүх ба баримт. Хоёр дахь хэвлэл. УБ., 2021, тал 123.

⁵ Харнууд З.Лонжид. Түүх сөхөхүй. УБ., 2011, тал 367.

⁶ Үндэсний статистикийн хорооны Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: <https://www.1212.mn/> (сүүлд хандсан: 2022.4.29)

⁷ У.Сайнбаяр. Монголын ховор ном, судар дэлхийн баримтат өвийн жагсаалтад бүртгэгдтээ. “Соёлын өвийн мэдээ, мэдээлэл” сэтгүүд. 2011 оны 1/№5. УБ., 2011, тал 35.

⁸ <http://unesco.mn/nm/communication-and-information/programmes/memory-of-the-world-programme/>

эрдэмтэн мэргэдийн бүтээсэн 1.5 сая орчим ном судар, “Дорно дахины ном, хэвлэлийн сан хөмрөг”-т 100 гаруй мянган, нийт 3 сая гаруй ном, судар хадгалагдаж байна. 2012 оны улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогоор бүртгэлийн программд орсон 34 музейн цуглуулгаас баримтат өвд хамаарах дурсгалыг шүүж үзэхэд зөвхөн бурханы зураг л гэхэд 9152 байна.⁹

ЮНЕСКО-гийн Дэлхийн дурсамж хөтөлбөрийн олон улсын жагсаалт (Дэлхийн баримтат өвийн жагсаалт)-д Монгол улсаас 6-н баримтат өв бүртгэгдсэн. Үүнд, Монгол Шунхан Данжуур (2011 он), Есөн эрдэнийн Ганжуур (2013 он), Данжуурын гэрэлт хөшөө (2017 он), ЮНЕСКО-ийн Дэлхийн дурсамж хөтөлбөрийн Ази-Номхон далайн бүс нутгийн жагсаалтад Монгол улсаас 3 баримтат өв бүртгэгдсэнд: Лу Алтан Товч (2010 он), Сахиусан Дара Эх (2014 он), Мэргэд гарахын орон нэрт нэр томьёоны толь бичгийн модон бар (2016 он) тус тус орж байна¹⁰. Ийнхүү 2011 онд “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн Олон улсын зөвлөлдөх хорооны ээлжит 10 дугаар бага хурлаар гишүүн орнуудаас нэр дэвшүүлсэн нийт 80 гаруй баримтат өвөөс 45 хосгүй үнэт баримтат өвийг Дэлхийн баримтат өвд бүтгэсэн юм. Энэ дотор Монгол улсаас Лувсанданзаны “Алтан товч” болон “Монгол шунхан Данжуур” бүртгэгдсэн нь Монгол улсаас Дэлхийн баримтат өвд бүртгэгдсэн анхны өвүүд болжээ.¹¹ Энэчлэн эрдэнэсээр бүтээгдсэн Буддын шашны хөлгөн судрууд нь монгол урчууд, эрдэмтэн лам нарын ном бүтээх ур чадварыг илгэх төдийгүй монголчуудын эрдэм мэдлэгийг хүндэтгэх соёлын түвшнийг илтгэх дурсгалууд юм.

1972 онд баталсан Дэлхийн

байгалийн болон соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн конвенцийн дагуу 2020 оны байдлаар 167 улсын нийт 1121 байгалийн болон соёлын өв Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлээд байна.¹² Монгол Улс тус конвенцод 1990 онд нэгдэн орж, улмаар Дэлхийн өвийн жагсаалтад 2020 оны байдлаар таван өвийг бүртгүүлжээ. Үүнээс соёлын ангиллаар бүртгэгдсэн Орхоны хөндийн соёлын дурсгалт газар (2004 он)-т Монголын бурханы шашны анхны төв Эрдэнэзуу хийд, Өндөр гэгээн Занабазарын нямба бясалгалын орон Төвхөн болон Шанхын баруун хүрээ хийдүүд зэрэг түүх, соёлын хосгүй үнэт сүм хийдийн уран барилгын дурсгалууд багтдаг. ЮНЕСКО Орхоны хөндийн соёлын дурсгалт газрыг Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэсэн тухай албан ёсны шийдвэр дэх шалгуур үзүүлэлтийн дөрөвдүгээрт “Орхоны хөндий нь хүн төрөлхтний түүхийн ач холбогдол бүхий хэд хэдэн үе шатыг илтгэн харуулдаг хосгүй гайхамшигт үлгэр жишээ болдог. Орхоны хөндийн соёлын дурсгалт газар нь эн тэргүүнд, тухайн үеийн Монголын эзэнт гүрний төв байсныг, хоёрт, Түрэгийн засгийн эрх мэдлийн Монгол өвөрмөц хувилбар болохыг харуулдаг, гуравт, ном бясалгалын орон хийд - Төвхөн нь буддизмын Монгол хэлбэр өрнөн хөгжих орчин болдог”¹³ гэжээ.

Монгол улсын Засгийн газрын 2004 оны 5 сарын 26-ны 126 дугаар тогтоолоор хуучин Баруун хүрээний туурийн хамгаалалтын бүсийг 220 га газар байхаар тогтоож, 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 13 дугаар тогтоолоор Шанхын хийдийн дуганууд нэрээр улсын хамгаалалтад авсан байна.¹⁴ Мөн Баруун хүрээ нь Засгийн Газрын тогтоолоор түүх, соёлын “хосгүй үнэт” зэрэглэлд

9 Ш.Энхтуяа. Баримтат өвийн тухай. “Соёлын өвийн мэдээ, мэдээлэл” сэтгүүл (2011-2018). №8. УБ., 2011, тал 47.

10 Соёлын өвийн сүлжээ, харилцаа холбооны зөвлөл: <https://barimtativ.mongoluv.mn/Mongolia-Documentary-Heritage>

11 Соёлын өвийн сүлжээ, харилцаа холбооны зөвлөл: <https://barimtativ.mongoluv.mn/Mongolia-Documentary-Heritage/4>

12 ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс: <http://unesco.mn/mn/soyol/delhiin-uv/>

13 Дэлхийн өв – Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны вэйб сайт: <https://orkhonvalley.gov.mn/orkhonvalley-world-heritage-site>

14 Дэлхийн өв – Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны вэйб сайт: <https://orkhonvalley.gov.mn/orkhonvalley-world-heritage-site>

батлагдсан 18 дурсгалт зүйл буюу хосгүй үнэт зэрэглэлийн хамгийн олон дурсгалыг хадгалж байдаг сүм хийд гэдгээрээ онцлог юм.

Мөн Өмнөговь аймгийн Номгон сумд орших 1707 онд байгуулагдсан, 300 гаруй жилийн түүхтэй “Сангийн далай” хийдийг 2009 оны 8 сард ЮНЕСКО-оос Ази, Номхон далайн бүсийн соёлын “Түүхийн дурсгалт өвийн хадгалалт, хамгаалалтын шилдэг өв”-өөр шалгаруулсан юм. Тухайн жил уг шагналд Ази, Номхон далайн 14 орны түүх, соёлын 48 дурсгалт зүйл нэр дэвшсэнээс Сангийн далай хийд шалгарсан нь хоёр, гурван зууны өмнөх монголчуудын соёл, гоо сайхны үнэлэмж, барилга байгууламжийн ур хийц, онцлогийг илэрхийлсэн, эдүгээ хийц бүтээц, төлөвлөлт, архитектурын хэв маяг, анхны дүр төрхөө хэвээр хадгалан үлдсэн байдлыг нь үнэлэн бүртгэсэн хэрэг юм. Сангийн далай хийд бол өдгөөгөөс 90 хүрэхгүй жилийн өмнө Монгол оронд байсан долоон зуу гаруй сүм хийдийн зөвхөн нэг нь бөгөөд хэлмэгдүүлэлтийн үед устгагдалгүй үлдэж хоцорсон нь өнөөдөр ийнхүү дэлхийд үнэлэгдэж буй.

ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн жагсаалтад түүх, соёлын дурсгалыг бүртгэх нь түүний үнэ цэнийн хамгийн дээд илэрхийлэл болдог. Өнөөдөр Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалтад Соёлын өвийн ангиллаар Монгол Улсаас 12 газар орсноос Буддын уран барилгын дурсгалууд оршин буй Сэлэнгэ аймгийн Амарбаясгалант хийд, түүнийг хүрээлсэн тахилгат газар болон Хэнтий аймагт орших Балдан Бэрээвэн хийд, түүнтэй холбогдох тахилгат газар нутаг багтжээ.

Монголын Бурханы шашны соёлын өв нь Монголын үндэсний соёлын салшгүй хэсэг юм. Монголчуудын бүтээсэн буддын соёлын хосгүй үнэт дурсгалууд нь дэлхий дахинд Монголчуудын хүрсэн соёлын

түвшнийг илтгэхийн сацуу өнөөдөр олон улсад өөрийн гэсэн байр суурийг нэгэнт эзлэх болсон билээ.

2. Соёлын өвийн Улсын Нэгдсэн Бүртгэл Мэдээллийн санд бүртгэлтэй Буддын соёлын биет өвийн дурсгалууд

Түүх, соёлын дурсгалыг бүртгэн баримтжуулах нь соёлын өвийг хадгалж хамгаалах ажил нь эхлэл юм. Монгол нутагт түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг шинжлэх ухааны үндэстэй бүртгэх, шинжлэн судлах ажил 1889 оны Оросын эрдэмтэн Н.М.Ядринцев, 1891 оны В.В.Радлов нарын хайгуул, шинжилгээний ангийн судалгаагаар эхэлсэн гэж үздэг. Манай улсын хувьд түүх, соёлынхоо үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулж, мэдээллийн сан бүрдүүлэх ажил 1921 онд Судар бичгийн хүрээлэн байгуулагдсанаар эхэлжээ.

Засгийн газраас 1924 оны 9 сарын 5-нд “Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм” баталж, түүнд хуучны зүйлд багтах түүх, соёлын дурсгалын төрлийг тодорхойлон, судлан шинжлэх, хайгуул малтлага хийх, энэхүү ажлыг гүйцэтгэх болон эх түүхэнд холбогдох дурсгалыг хилээр нэвтрүүлэхэд олгох зөвшөөрлийг Судар бичгийн хүрээлэнгээс удирдан эрхлэх бөгөөд “ижилгүй ганц нэгэн ховор юмыг гадаадад гаргуулж үл болно”¹⁵ гэж заажээ. Мөн “Монгол Улсын Судар бичгийн хүрээлэнгийн эрхлэх үйлдвэрийн товчоо”-ны 6 дугаар зүйлд “Эрт балар цагаас нааш эдүгээ хүртэл мөргөл шүтлэгт хамаатай зүйлүүдийг цуглуулна... эдүгээ цагийн шашин мөргөлийн зан үйлс нь хэрхэн, хаанаас гарч хэрхэн уламжлан ирснийг шинжилнэ... [үүний] тулд эрхбиш Судар бичгийн хүрээлэнд... Шашин мөргөлийн зүйлийг шинжлэх кабинет... байх хэрэгтэй”¹⁶ гэсэн буй.

¹⁵ Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. Хоёрдугаар боть (1911-1926.V сар). Ерөнхий редактор Б.Чимид. УБ., 2010, тал 492.

¹⁶ Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. Хоёрдугаар боть (1911-1926.V сар). Ерөнхий редактор Б.Чимид. УБ., 2010, тал 495.

Судар бичгийн хүрээлэн байгуулагдсанаар Монгол орны түүх, соёл, угсаатан, шашин мөргөл, эртний судлалд холбогдох мэдээ баримт, эдлэл хэрэглэгдэхүүн цуглуулах ажил өрнөж “1922 онд Судар бичгийн хүрээлэнгээс эрхлэн өнөөгийн Төв, Архангай, Булган, Өвөрхангай аймгийн нутгаар хайгуул шинжилгээний ажил хийж Сарьдгийн хийд, Эрдэнэзуу, Баруун хүрээ зэрэг уран барилгын дурсгалыг бүртгэж гэрэл зургаар баримтжуулж байжээ”.¹⁷ Зөвхөн улсын дотоодод төдийгүй хилийн чанад дахь Монголын түүх, соёлд холбогдох ховор нандин ном судрыг эрэн сурвалжилж, цуглуулах ажлыг хийж байв. Тухайлбал, эдүгээ Монгол Улсын Үндэсний номын сангийн үнэт ховор номын тасагт хадгалагдаж буй “Монгол шунхан Данжуур”-ын 226 ботийг 1925 онд Судар бичгийн хүрээлэнгийн дарга Онходын Жамъян гүн, жонон ван Ширнэндамдин нар Бээжинд суугаа Халхын Сэцэн чин ван Наянтаас залж ирсэн түүхтэй.

Монгол Улсад соёлын өвийг бүртгэн баримтжуулж мэдээллийн сан бүрдүүлэх нэгдсэн тогтолцоо 1996 оноос бүрдэж эхэлсэн гэж үздэг. 1994 онд батлагдсан “Түүх, соёлын дурсгалыг хамгаалах тухай” хуульд үндэслэн 1996 онд Соёлын сайдын түүх, соёлын дурсгалт зүйлийн УНБМС-г байгуулахаар шийдвэрлэжээ. Эдүгээ соёлын өвийн УНБМС нь олон улсын нийтлэг зарчмын дагуу Монгол нутаг дахь соёлын өвийг түүх, соёлын хөдлөх, үл хөдлөх (соёлын биет өв), утга соёлын (соёлын биет бус өв) хэмээн 3 ангилж мэдээллийн сан бүрдүүлж байна.¹⁸

“Дэлхийн соёлын болон байгалийн

өвийг хамгаалах конвенц”-д “Соёлын өв” гэдэг ойлголтыг үл хөдлөх дурсгал гэсэн утгаар нь хөшөө дурсгал¹⁹, уран барилгын чуулган²⁰, түүхийн дурсгалт газар²¹ гэж гурав ангилсан байна.²²

Соёл бол биет болон биет бус өвийн тогтолцоо юм. Манай улсын хувьд 2014 онд шинэчлэн баталж, 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан “Соёлын өвийг хамгаалах тухай” хуульд соёлын өвийг ангилж, төрөл зүйлээр нь ялгаж тодорхойлжээ. Хуулийн 3.1-д “соёлын өв гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэн, ач холбогдол бүхий өвийг” хэлнэ. Хуулийн 3.1.6-д “соёлын өвийн дурсгалт газар” гэж соёлын биет болон биет бус өв нь байгаль орчин, уламжлалт ахуйтайгаа харилцан шүтэлцсэн соёлын орон зай, газар нутгийг; 3.1.7-д “түүх, соёлын дурсгалт газар” гэж энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан түүх, соёлын үл хөдлөх дурсгал бүхий газар, түүний хэвлийг хэлнэ хэмээжээ.

Мөн хуулийн 2 дугаар бүлгийн 4.1-д “Соёлын өвийг биет ба биет бус гэж ангилна”; 3.1.2-д “соёлын биет өв” гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа дурсгалыг; 3.1.5-д “соёлын биет бус өв” гэдэг нь “хамт олон, бүлэг, хувь хүн соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн зан заншил, дүрслэх болон илэрхийлэх хэлбэр, уламжлалт мэдлэг, арга барил, тэдгээртэй холбоотой эд өлгийн зүйл, зэмсэг, урлагийн бүтээл, соёлын орон зайг”; 4.2-д Соёлын биет өвийг түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт

¹⁷ Г.Анхсанаа, Г.Энхбат, А.Цоож. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. XII дэвтэр - Өмнөговь аймаг. Соёлын өвийн төв. УБ., 2019, тал 7.

¹⁸ Г.Анхсанаа, Г.Энхбат, А.Цоож. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. XII дэвтэр - Өмнөговь аймаг. Соёлын өвийн төв. УБ., 2019, тал 7.

¹⁹ Түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнэ бүхий уран барилга, сүрлэг чимэглэлийн уран баримал, уран зургийн бүтээл, археологийн олдворууд, бичээс, агуй болон цогцолбор дурсгалууд.

²⁰ Түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнэ бүхий салангид буюу нэгдмэл барилга байгууламж уран барилгуудын цогцолбор.

²¹ Хүний болон хүн, байгалийн хамгарсан бүтээлүүд мөн түүх, гоо зүй, угсаатны судлалын хувьд дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнэ бүхий археологи, түүхийн дурсгалт газрыг багтаасан бүс нутгийг оруулна.

²² Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах конвенц (1972): <http://unesco.mn>

зүйл гэж ангилна ; 3.1.3-д “түүх, соёлын үл хөдлөх дурсгал” гэж унаган газартаа хүрээлэн байгаа орчны хамт үнэ цэн, ач холбогдол нь илэрхийлэгдэх дангаар болон цогцолбор байдлаар орших дурсгалыг; 3.1.4-д “түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл гэж тодорхой орон зайд шилжүүлэн байрлуулах боломжтой дурсгалыг” хэлнэ гэж тус тус тодорхойлжээ. Улмаар “соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамааруулна” хэмээгээд хуулийн 5.1-д түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг 11 төрөл зүйлд ангилсны 5.1.6-д “эртний хот суурин, сүм хийдийн үлдэгдэл, түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгал” гэж заасан буй.²³

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл ба Буддын шашны суварга, сүм хийдийн дурсгалын тоо. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйл “Соёлын өвийн үзлэг, тооллого”-ын тухай заалтад үндэслэн 2015-2016 онд БСШУЯ-аас түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын үзлэг, тооллогыг анх удаа зохион байгуулжээ. Улсын тооллогоор Монгол Улсын 21 аймаг, 330 сум, нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэр дэх 9537 дурсгалт газарт орших 86157 үл хөдлөх дурсгалыг тоолж²⁴, түүнийг 8 төрөлд ангилж бүртгэсэн байна. Дор дурсгалын төрөл, тоо, эзлэх хувийг үзүүлье. Үүнд:

1. Эртний булш оршуулгын дурсгал 67927 (нийт дурсгалын 79%);
2. Хадны зураг, бичгийн дурсгал 6796 (8%);
3. Чулуун зэвсгийн дурсгалт газар 131 (0.15%);
4. Хөшөө дурсгал 4230 (5%);
5. Тахилга тайлгын байгууламж 4167 (5%);
6. Барилга, архитектурын дурсгал 2820

(3%);

7. Палеонтологийн дурсгалт газар 51 (0.05%);
8. Үйлдвэрлэлийн үл мөр хадгалсан дурсгалт газар 35 (0,04%).²⁵

Эндээс үзвэл, Монгол оронд буй Буддын соёлын үл хөдлөх дурсгал болох суварга, сүм хийд, сүм хийдийн туурь нь түүх, соёлын дурсгалын дээрх 8 төрөл ангиллын барилга, архитектурын төрөлд багтах бөгөөд Монголд “2820 барилга, архитектурын дурсгал байгаагийн 596 нь сүм хийд”²⁶ байна. Суварга, сүм хийд, түүний үлдэгдэл гэдэгт түүхэн тодорхой цаг үед шашны хурал номын үйл ажиллагаа явуулж байсан мөргөл, хүндлэлийн орон байгаад хожим нь эвдэрч сүйдсэн болон эргэж сэргээн засварлагдсан суварга, сүм хийд, түүний туурь үлдэгдлийг хэлдэг ажээ.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл ба шашны дурсгалт зүйлийн тоо. Төрөөс түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл, тооллогыг 2006-2008 онд, 2012-2014 онд, 2018-2019 онд нийт гурван удаа зохион байгуулсан байна. Эхний хоёр нь “Музейн сан хөмрөгийн улсын тооллого” нэртэй явагдсан бол 2018-2019 онд “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллого” нэрээр аймаг, нийслэлийн хэмжээнд 307 байгууллагыг хамруулснаас Бурханы шашны 3 сүм хийд багтжээ.

Энэхүү улсын тооллогоор 127264 дэсийн 277019 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл тоологдохоос 126810 дэсийн 276077 ширхэг дурсгалт зүйлийг тоолж бүртгэн, дурсгалуудыг 6 төрөлд ангилжээ. Үүнд:

²³ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail/10439>

²⁴ Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн тоо баримт. СӨҮТ-ийн вэб хуудас дахь УНБМС-ийн танилцуулга: <https://ncch.gov.mn/Files/Report/Soyoliin%20uviiin%20UNBMSangiin%20taniltsuulga.pdf>

²⁵ Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн тоо баримт. СӨҮТ-ийн вэб хуудас дахь УНБМС-ийн танилцуулга: <https://ncch.gov.mn/Files/Report/Soyoliin%20uviiin%20UNBMSangiin%20taniltsuulga.pdf>

²⁶ Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төслийн төгсгөлийн тайлан. Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яам, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Жайка). УБ., 2021, тал 17.

1. Түүхийн холбогдолтой цуглуулга - 29%
2. Шашин шүтлэгийн холбогдолтой зүйл - 22%
3. Угсаатны зүйн цуглуулга - 16%
4. Байгалийн түүхийн холбогдолтой - 13%
5. Урлаг, уран сайхны холбогдолтой - 13%
6. Археологийн олдвор 7% - ийг тус тус эзэлж байна.²⁷

Энд бүртгэгдсэн 276077 ширхэг түүх, соёлын дурсгалт зүйлээс 22 хувь буюу 24114 дэсийн 58412 ширхэг нь шашин шүтлэгийн холбогдолтой дурсгалт зүйл байна.²⁸ Үүний 13375 дэсийн 31265 нь улсын 10 музей, эрдэм шинжилгээний 2 хүрээлэн, 1 номын сан, 3 их сургууль, 2 сүм хийдээс, харин 10739 дэсийн 27147 ширхэг нь аймаг, орон нутаг, нийслэлийн 24 музей, байгууллагын 3 музейд хадгалагдаж тус тус бүртгэгджээ. Энэ удаагийн улсын тооллогоор 99 байгууллагын 435 дэсийн 875 ширхэг хөдлөх дурсгалт зүйл дутсан, хулгайд алдсан, солигдсон шалтгаанаар тоологдоогүйгээс 74 нь шашин шүтлэгийн холбогдолтой дурсгалт зүйл байжээ.

Сумдын Орон нутаг судлах танхимуудын хараа хяналт сулаас шалтгаалан ОНСТанхимын үнэ цэнтэй үзмэрийг дутаах, хувьдаа ашиглах, нуун дарагдуулах явдал байсаар байна. Тухайлбал, Дорнод аймгийн Баяндун сумын ОНСТ 2018 онд 16 дэсийн 51 ширхэг дурсгалт зүйлс бурхны танка зураг, бөөгийн толь, цөгц зэрэг ур хийц сайтай, үнэ цэнтэй үзмэрүүд дутаасныг аймгийн музей тус сумын цагдаагийн хэсэгт хандсан ч сумын цагдаагийн хэсэг хэрэг үүсгэн шалгахаас татгалзсан зэрэг хууль бус үйлдлүүд гарч байсныг тооллогын комисс илрүүлжээ.²⁹

2020 онд Соёлын өвийн УНБМС-д 966 дэсийн 1422 үзмэр баяжилтаар нэмэгдсэний 11.3 хувь буюу 160 нь шашин шүтлэгийн дурсгалт зүйл байна. 2018-2019 онд хийсэн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогоор нийт 58412 ширхэг шашин шүтлэгийн дурсгалыг 4 төрөл, 111 бүлэг зүйлд ангилж бүртгэжээ. Үүнд:

1. Бөө мөргөлийн эд өлгийн зүйл (2 төрөл, 7 бүлэг)
2. Бурханы шашны эд өлгийн зүйл (16 төрөл, 99 бүлэг)
3. Исламын шашны эд өлгийн зүйл (4 төрөл)
4. Бусад (1 төрөл)

Энэхүү үзлэг, тооллогод зориулж дурсгалуудыг бүртгэх төрөл зүйлийн ангиллыг шинэчлэн боловсруулж, ингэхдээ үндсэн 6 ангилснаа баримтлан Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн нэр томъёо, Сангийн сайдын 2013 оны 140 дүгээр тушаалаар батлагдсан “Түүх, соёлын дурсгал, үзмэр эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнийн жагсаалт”-д оруулсан үзмэрийн төрөл зүйл, нэр томъёо зэргийг баримтлан ангиллыг нэмжээ. Энэ үед “шашин шүтлэг”-ийн холбогдолтой төрөл зүйлийг дотор нь бүлэглэж, зарим нэг ангиллыг нэмсэн байна. Тухайлбал, бурханы шашны холбогдолтой бүлэгт “Судар ном” гэсэн ангиллыг нэмсэн. Өмнө нь “Түүхийн холбогдолтой” төрөл зүйлийн “Ном, хэвлэл, бичгийн хэрэгсэл” дотор бүх төрлийн ном хэвлэл, үүнд дотроо шашны судрыг оруулдаг байсан нь ном хэвлэлийн ангилал ялгаа, тоог гаргахад бодитой бус байдлыг залруулан тус тусад нь ангилал болгосон зэрэг нэмэлт өөрчлөлтүүдийг хийжээ.³⁰ Ийнхүү өөрчилсний үр дүнд үзмэрийн төрөл зүйлийн тоог илүү нарийн гаргах боломжтой болсон байна.

²⁷ Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны үр дүнгийн гэрээний биелэлтийн нэгдсэн дэлгэрэнгүй тайлан. УБ., 2019, тал 14. СӨҮТ-ийн вэб хуудас: <https://ncch.gov.mn>

²⁸ Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны үр дүнгийн гэрээний биелэлтийн нэгдсэн дэлгэрэнгүй тайлан. УБ., 2019, тал 15.

²⁹ Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны үр дүнгийн гэрээний биелэлтийн нэгдсэн дэлгэрэнгүй тайлан. УБ., 2019, тал 16-17.

³⁰ Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллого (2018-2019 он). УБ., 2018, тал 54.

Буддын шашны хосгүй үнэт дурсгалт зүйл. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн Соёлын өвийн ангилал, зэрэглэлийн тухай 2 дугаар бүлгийн 8.2-д “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн эх төрх бүрэн бүтэн байдал, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэн, ач холбогдлыг харгалзан үнэт, хосгүй үнэт зэрэглэл тогтооно” гэжээ. Хуульд заасан шалгуурыг үндэслэн БСШУСЯ-ны дэргэдэх түүх, соёлын дурсгалын зэрэглэлийг тодорхойлох Мэргэжлийн зөвлөл нь Соёлын өвийн үндэсний төвийн УНБМСанд бүртгэлтэй дурсгалуудаас сонгон хосгүй үнэт, үнэт зэрэглэлд хамруулахыг тодорхойлж Засгийн газарт өргөн мэдүүлдэг байна.

1995 онд Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор нийт 39 дурсгалыг түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлд баталж байсан бол түүнээс хойш Засгийн газрын нийт 18 удаагийн тогтоол шийдвэр гарч, 2021 оны байдлаар манай улсын нэр бүхий 27 байгууллагад хадгалагдаж буй 778 хөдлөх дурсгалт зүйлийг Монгол Улсын “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д бүртгэсэн байна.³¹ Хосгүй үнэт дурсгалуудад Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас гэрчилгээ олгодог.

Музей, номын сан, Эрдэнэсийн сан, эрдэм шинжилгээний хүрээлэн, их сургууль, сүм хийд зэрэг төрийн, орон нутгийн болон шашны байгууллагад хадгалагдаж буй хосгүй үнэт дурсгалуудаас Монголын Бурханы Шашинтны Төв Гандантэгчэнлин хийдэд 15, Өвөрхангай аймгийн Шанхын баруун хүрээ хийдэд 18 (цутгамал баримал 4, танка зураг 9, монгол зураг 1, хөгжмийн зэмсэг 1), Төвхөн хийдэд 1, Дундговь аймгийн Баруун чойрын хийдэд 1 буюу нийт шашны өмчийн 4 сүм хийдэд 35 хосгүй үнэт дурсгалт зүйл хадгалагдаж байна.³² Үүнээс гадна, Богд хааны ордон музейд 79, Чойжин ламын сүм музейд 38, Эрдэнэзуугийн музейд 93 тооны дурсгал хадгалагдаж байна. Эдгээр нь үндсэндээ бурханы шашны түүх, соёлын дурсгалууд болно.

Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хөдлөх дурсгалт зүйлийн ангиллаар “соёлын” болон “байгалийн” өвийн³³ холбогдолтой дараах 6 төрөлд хуваадаг.³⁴ Үүнд:

³¹ Монголын түүх, соёлын “хосгүй үнэт” дурсгалт зүйлийн жагсаалт. СӨҮТ-ийн Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээлэл: http://ncch.gov.mn/files/download/Unique_Objects.pdf

³² Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн тоо баримт. СӨҮТ-ийн вэб хуудас дахь УНБМС-ийн танилцуулга: <https://ncch.gov.mn/Files/Report/Soyoliin%20uviiin%20UNBMSangiin%20taniltsuulga.pdf>

³³ Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төслийн төгсгөлийн тайлан. Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яам, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Жайка). УБ., 2021, тал 17.

³⁴ Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийн төрөл зүйлийн ангиллаар.

Зураг №1. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн төрөл зүйлийн үзүүлэлт (1995-2019)³⁵

Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн төрөл зүйлийн үзүүлэлт (1995-2019)



Хосгүй үнэт дурсгалын 35.2 хувьд нь шашин шүтлэгийн холбогдолтой 274 дурсгал багтсан ба СӨҮТ-ийн мэдээлэлд 9 төрөлд ангилжээ. Үүнд³⁶:

- Шүтээн урлалын цутгамал 133 хосгүй үнэт дурсгалт зүйл
- Танка зураг 67 хосгүй үнэт дурсгалт зүйл
- Зээгт намаал, танка зургийн 35 хосгүй үнэт дурсгалт зүйл
- Хөөмөл урлалын 23 хосгүй үнэт дурсгалт зүйл
- Сийлбэр урлалын 6 хосгүй үнэт дурсгалт зүйл
- Цамын баг, өмсгөлийн 6 хосгүй үнэт дурсгалт зүйл
- Шашны зан үйлийн холбогдолтой 2 хосгүй үнэт дурсгалт зүйл
- Баримал шуумлын урлалын 1 хосгүй үнэт дурсгалт зүйл
- Шашны хөгжмийн зэмсэг 1 хосгүй үнэт дурсгалт зүйл байна.

Бурханы шашин XVI зуунаас Монголд хүчтэй дэлгэрч, буддын дотоод ухаан (гүн ухаан)-д суурилсан бие, хэл, сэтгэлээр урлах эрдэм ухаан монголчуудын урлаг, гоо зүй, оюун санааны ертөнцөд нэвтэрч, анхдугаар богд Өндөр гэгээн Занабазар тэргүүтэй монгол урчууд төрж, Монголын дүрслэх урлагийн гайхамшигт ур хийцтэй бүтээлээрээ монгол дэг сургуулийг бий болгосон түүхтэй. Иймээс түүх, соёлын хосгүй үнэт дурсгалд багтсан шашны урлагийн шилдэг бүтээлүүд нь шүтээн цутгамал, шүтээн зураг, зээгт намаал, хөөмөл, сийлбэр, баримал шуумлын урлал зэрэг уламжлалт урлан бүтээх аргаар бүтээгдсэн нь олонх байдаг.

Эдгээрээс Монголдоо төдийгүй дэлхийд нэр хүндтэй бурханы шашны шедерүүдийг дурдвал, анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазарын бүтээсэн Гандантэгчэнлин хийд болон Шанхын Баруун хүрээ хийдэд хадгалагддаг “Очирдара” бурхан, Богд хааны ордон музей, Дүрслэх урлагийн музей болон Чойжин ламын сүм музейд хадгалагдаж

³⁵ “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн төрөл зүйлийн үзүүлэлт”, СӨҮТ-ийн СӨУлсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээлэл: https://ncch.gov.mn/Files/Download/Unique_Objects_Classification.pdf

³⁶ “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн төрөл зүйлийн үзүүлэлт”, СӨҮТ-ийн СӨУлсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээлэл: https://ncch.gov.mn/Files/Download/Unique_Objects_Classification.pdf

буй “Язгуурын таван бурхан”³⁷, Цагаан болон Ногоон Дара эх тэргүүтэй 21 Дара эх зэргийг нэрлэж болно.

Мөн Дүрслэх урлагийн болон Чойжин ламын сүм музейд хадгалагдаж байгаа XIX зууны үед Их хүрээний Эрхэм тойн аймгийн уран Пунцаг-Осорын бүтээсэн Жамсрангийн цамын иж бүрэн өмсгөл, цаасан шуумал дээр час улаан шүрийг хэлхэж бүтээсэн Улаан сахиусны цамын гурван баг, монгол урчууд, дархнуудын алт, мөнгө, 9 эрдэнийн чулуугаар бүтээсэн “Сандуйн жүд” судар (Үндэсний номын сан), Есөн эрдэнийн Ганжуур, Жадамба судрын зэс бар, эртний ном судар, шүтээн зураг, өнгийн торго хоргой, эрдэнийн чулуу шигтгэн урласан ур тансаг хийцтэй зээгт наамал зэрэг шашны урлагийн бүтээлүүд, Халхын найман Богд богдоор дамжин уламжлагдаж ирсэн хувцас, эд зүйлс, Богд хаан, Дондогдулам хатан нарын төрийн ёслолын хувцас, говийн ноён хутагт Данзанравжаагийн малгай, эд хэрэглэл³⁸ болон түүхэн бие хүнд холбогдох дурсгалууд зэрэг шашны холбогдолтой түүх өгүүлсэн урлагийн бүтээлүүд багтдаг.

Шашны холбогдолтой дурсгалт зүйлд зэрэглэл тогтоохдоо түүхэн он цагаас илүүтэй ур хийц, дэг сургуулийг нь чухалчлан үздэг. Мөн түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэл дэх шашны эд зүйл, цутгамал, танка, зээгт наамал зэрэг бүтээлүүдийн судалгаа өнөө хэр дутуу дулимаг байгааг мэргэжилтнүүд цохон тэмдэглэдэг.³⁹

3. Төрийн хамгаалалтад байгаа Буддын соёлын үл хөдлөх дурсгалууд

Монголчуудын нүүдэллэн аж төрөх хэв маяг нь сав, шим ертөнцийн зохист уялдааг танин барьж, байгаль дэлхий,

хүрээлэн буй орчноо хамгаалах, зөв зохистой ашиглах мэдлэг ухаанд суурилсан гэж үздэг. Монголчууд эртнээс нааш гол мөрөн, уул хангай, байгалийн өвөрмөц тогтоцтой мод, хад чулууг ариун дагшин хэмээн үздэг ба дурсгалт газар, эрдэс баялаг хийгээд хүний гараар бүтээсэн түүх, соёлын дурсгалт зүйлсэд хүндэтгэлтэй ханддаг уламжлалтай. Хорио цээрийн ёс, төрийн хууль цааз, ардын уламжлалт сурган хүмүүжүүлэх ухаанд түүх, соёлын эд өлгийн зүйлсийг ухааж төнхөх, хөндөж сүйтгэхийг цээрлэж ирсэн нь өнөө хэр хэвээрээ байна.

Монгол Улсад соёлын өвийг хамгаалах талаар төрийн цэгцтэй бодлого Ардын хувьсгал ялсны дараагаас боловсорч иржээ. 1921 онд байгуулагдсан Судар бичгийн хүрээлэнгийн дүрэмд “дэлхий дахины улсын бичиг судрын сан ба музей үзмэрийн зүйлийг хураах... монгол үндэстэнд холбогдох бичигтэй хөшөө, чулуун зураг зүйлүүдийг хамгаална” гэж заасан байдаг нь төрөөс соёлын өвийн талаар баримтлах анхны эрхзүйн баримт болжээ.⁴⁰

Засгийн газраас 1924 онд баталсан “Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм”-ийг 1941 онд Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 79 дүгээр тогтоолоор “Хуучны дурсгалт зүйлсийг сахин хамгаалах дүрэм” нэрээр шинэчлэн баталж, эртний хот балгас, хэрмийн үлдэгдэл зэрэг 15 дурсгалыг улсын нэгдүгээр зэрэглэлийн хамгаалалтад, Эрдэнэ зуу, Амарбаясгалант, Онгийн хийд, Жанрайсэгийн дуган, Гүнжийн сүм, Гэсэр сүм, Чойжин ламын сүмийн халх хаалга зэрэг 16 дурсгалыг улсын хамгаалалтад бүртгэн авсан байна. Энэ бол Монгол улс анх удаа төрийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн жагсаалтыг баталсан түүхэн шийдвэр байсан болно.

³⁷ Язгуурын таван бурхдын нэр нь Маш гийгүүлэн зохиогч, Цаглашгүй гэрэлт, Үйл бүтээгч, Үл хөдлөгч, Эрдэнэ үүсгэгч.

³⁸ Д.Нарантуяа. Монголын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалууд. “Соёлын өв” мэдээллийн сэтгүүл. №1. УБ., 2008, тал 33.

³⁹ “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн төрөл зүйлийн үзүүлэлт”, СӨҮТ-ийн СӨУлсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээлэл

⁴⁰ Г.Анхсанаа, Г.Энхбат, А.Цоож. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. XII дэвтэр - Өмнөговь аймаг. Соёлын өвийн төв. УБ., 2019, тал 5.

1960 оны 4 дүгээр сарын 11-нд МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооноос Богдын ногоон сүм (одоогийн Богд хааны ордон музей), Чойжин ламын сүм, Гандантэгчэнлин хийд, Жанрайсэг дацан, Гэсэр сүм, чин ван Ханддоржийн өргөө зэрэг түүх, соёлын дурсгалт газруудыг улсын хамгаалалтад авч музей, үзвэрийн газар байгуулах тухай тогтоол гаргажээ. Тус тогтоолд Чойжин ламын сүм, Богдын ногоон ордныг 1961 оны 5 дугаар сарын 1-ний дотор сэргээн засварлаж үзвэрийн зориулалтаар ашиглах талаар заажээ. Үүний дараахан 1961 оны 10 дугаар сарын 9-нд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 524 тоот тогтоолоор Чойжин ламын сүм музейг цогцолбороор нь, Эрдэнэ зуу, Амарбаясгалант хийд, Жанрайсэгийн дацан, Гүнжийн сүм, Богдын ногоон ордон, Ноён уулын Хүннүгийн язгууртны булш зэрэг түүх, соёлын дурсгалыг улсын 1-р зэргийн хамгаалалтад авсан байна.⁴¹

Монгол Улсын Засгийн газар 2008 оны 5 дугаар сарын 14-ний 175 дугаар тогтоолоор “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг батлав. Тус жагсаалтад 21 аймаг, Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх нийт 452 дурсгалыг оруулжээ. Улсын хамгаалалтад авсан 175 дурсгалаас 19 нь, аймаг, нийслэлийн хамгаалалтад авсан 275 дурсгалаас 23 нь буюу 42 дурсгалд Бурханы шашны суварга, сүм хийд, сүм хийдийн тууриуд багтсан байна.

2014 онд УИХ-аас Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг шинэчлэн найруулж, 2008 оны дээрх жагсаалтыг 2020 онд шинэчлэн баталжээ. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.1-д “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын эх төрх бүрэн бүтэн байдал, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэн, ач холбогдлыг харгалзан улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалтын зэрэглэл тогтооно” хэмээснийг үндэслэн Засгийн газар 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 13 дугаар тогтоолоор “Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг баталж, 21 дурсгалт газрын 185 түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг улсын хамгаалалтад авав. Мөн 2020 оны 3 сарын 30-ны өдөр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны сайдын А/161 тоот тушаалаар аймаг, нийслэлийн хамгаалалтад 607 үл хөдлөх дурсгал байхаар жагсаалтыг баталжээ. Ингэснээр өнөөдөр улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад нийт 792 дурсгал байна.

Улсын хамгаалалтад байгаа түүх, соёлын үл хөдлөх 185 дурсгалыг судалж үзэхэд 30 нь барилга, архитектурын төрөлд хамаарах буддын шашны суварга, сүм хийд, сүм хийдийн тууриуд буюу бурханы шашны уран барилгын дурсгалууд байна. Үүнд:

⁴¹ Г.Анхсанаа, Г.Энхбат, А.Цоож. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. XII дэвтэр - Өмнөговь аймаг. Соёлын өвийн төв. УБ., 2019, тал 9.

Хүснэгт 1. Улсын хамгаалалтад байгаа бурханы шашны үл хөдлөх дурсгалын жагсаалт (2020)

Д/д	Дурсгалын нэр	Сум	Аймаг
1	Луу гүний хүрээний дуганууд	Батцэнгэл сум	Архангай
2	Булган уулын бурхдын зураг	Эрдэнэбулган	
3	Зая гэгээний хийдийн цогцолбор	Эрдэнэбулган	
4	Бурхант хясааны бурхдын хөрөг, бичээс	Галуут	Баянхонгор
5	Чин сүжигт Номун хааны хийдийн цогцолбор		
6	Хачин ламын сүм		
7	Их бурхантын цогцолбор дурсгал	Халхгол	Дорнод
8	Хэрлэн барс хотын туурь, суварга	Цагаан-Овоо	Дундговь
9	Сүм Хөхбүрдийн балгас	Адаацаг	
10	Сангийн далай хийдийн Цогчин дуган	Эрдэнэдалай	
11	Үнстийн хийдийн Цогчин дуган		
12	Төвхөн хийд	Бат-Өлзийт	Өвөрхангай
13	Ханджамцын суварга		
14	Шанхын хийдийн дуганууд		
15	Эрдэнэ зуу хийдийн цогцолбор	Хархорин	
16	Дэмчигийн хийд,		Өмнөговь
17	Эрээтийн хийд		
18	Цогзолын хийдийн туурь	Ханбогд	
19	Амарбаясгалант хийдийн цогцолбор	Баруунбүрэн	Сэлэнгэ
20	Манзуширын хийдийн туурь, бурхдын зураг	Зуунмод	Төв аймаг
21	Сарьдагийн хийдийн туурь	Мөнгөнморьт	
22	Гүнжийн сүмийн үлдэгдэл	Эрдэнэ	
23	Балдан Бэрээвэн хийдийн цогцолбор, бурхдын зураг, бичээс	Өмнөдэлгэр	Хэнтий
24	Гандантэгчэнлин хийдийн цогцолбор	Баянгол	Улаанбаатар
25	Дарь-Эхийн сүмийн чулуун багана, гол сүм	Баянзүрх	
26	Дамбадаржаа хийдийн цогцолбор	Сүхбаатар дүүрэг	
27	Дашчойлин хийдийн гэр хэлбэрт модон дуганууд		
28	Чойжин ламын сүмийн цогцолбор		
29	Богд хааны ногоон ордны цогцолбор	Хан-Уул	
30	Гэсэр сүмийн цогцолбор	Чингэлтэй	

Дээрх дурсгалуудын зарим нь Монгол дахь бурханы шашны хөгжлийн эрт, дундад үед холбогдоно. Тухайлбал, Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутагт орших Хэрлэн барс хотын туурь дахь суварга нь X-XI зууны Кидан улсын үеийн сүм, суваргын туурь бөгөөд энэ нь Монгол дахь буддын шашны түрүү дэлгэрэлтийн үед хамаарна.

2020 онд БСИШУСЯ-ны сайдын баталсан Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх нийт 607 дурсгалаас бид шүүж үзэхэд 42 нь суварга, сүм хийд, түүний туурь зэрэг бурханы шашны үл хөдлөх дурсгалууд байна.

2021 оны эхний улиралд Барилга хот байгуулалтын яамны удирдлагаар хийсэн “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл”-ийн судалгааны хүрээнд сум, дүүргээс нийт 3739 дурсгалын мэдээ, бүртгэл ирснээс⁴², сум болон дүүргийн хамгаалалтад давхардсан байдлаар барилга,

⁴² Гэвч судалгааны тайланд, дээрх сумын болон дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт бүгд албажин батлагдаагүй гэдгийг тэмдэглэсэн байна.

архитектурын 189 дурсгал хамруулжээ⁴³. Эдгээрийн дотор бурханы шашны үл хөдлөх дурсгал буюу суварга, сүм хийд, түүний тууриуд нийт 149 байна.

Ингэж улсын хамгаалалтад 30, аймаг, нийслэлийн хамгаалалтад 42, сум, дүүргийн хамгаалалтад 149 буюу нийт бурханы шашны үл хөдлөх 221 дурсгал төрийн хамгаалалтын зэрэглэлд багтжээ.

Онцлон тэмдэглэхэд, улс, аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд авсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн жагсаалтыг 1941 (29), 1971 (127), 1994 (380), 1998 (352), 2008 (452), 2020 (792) онуудад нийт 6 удаа шинэчлэн батлахад, эдгээр жагсаалтад орсон шашны үл хөдлөх дурсгалууд нь бүгд Бурханы шашны дурсгалууд байна. Эндээс үзэхэд, Монгол орны нутаг дэвсгэр дээр байгаа бурханы шашны суварга, сүм хийд, сүм хийдийн туурь болох 600 орчим барилга, архитектурын дурсгал нь Монголын уламжлалт уран барилга, түүний хөгжлийг илтгээд зогсохгүй, Монголын эх түүх, соёлд үнэ цэнтэй болох нь нотлогдож байна. Нөгөө талаар Бурханы шашин нь Монгол нутаг даяар жигд дэлгэрч, улмаар Монголчуудын уламжлалт шашин болж хөгжсөн түүхийн бодит гэрч болж байна.

Бурханы шашны дурсгалт газрын хамгаалалтын цэс. 1994 онд батлагдсан “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль”-ийн 16.6-д “Эртний хот, суурины үлдэгдэл, байшин барилга, цогцолбор зэрэг түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн сүр барааг хадгалах зорилгоор эргэн тойронд нь 0.1-3 км-ийн хамгаалалтын бүсийг Засгийн газар тогтоож болно” гэж заасны дагуу түүх, соёлын үл хөдлөх дурсгалын түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлж чадах байдал, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэн, ач холбогдол, улсын хамгаалалтын

зэрэглэл зэргийг харгалзан үл хөдлөх дурсгалын хамгаалалтын бүсийг тогтоож эхэлжээ. Засгийн газрын 1997 оны 241 дүгээр тогтоолоор Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших Монголын эртний нийслэл Хархорум хотын туурийн хамгаалалтын бүсийг 9,69 км.кв талбайтай байхаар тогтоосон нь анхны хамгаалалтын бүстэй дурсгал болсон юм.⁴⁴ Соёлын өвийг хамгаалах тухай хуульд зааснаар Засгийн газар хамгаалалтын бүсийг тогтоох бөгөөд Соёлын өвийн дурсгалт газрыг “хамгаалалтын бүс” болон “орчны бүс”-д хуваана гэж заажээ.

Монгол Улсын Засгийн газар “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн холбогдох заалтыг үндэслэн улсын хамгаалалтын зэрэглэлд авч хамгаалалтын бүс тогтоосон газруудад Бурханы шашны түүх, соёлын дараах дурсгалт газрууд хамрагдсан байна. Үүнд: 2001 оны Засгийн газрын 96 дугаар тогтоолоор Гандантэгчинлэн хийд, Гэсэр сүм, Богд хааны ногоон ордон, Чойжин ламын сүм, Дамбадаржаа хийд, Гэр хэлбэрт модон дуганууд буюу Дашчойлин хийдийн хамгаалалтын бүсийг; 2002 оны 71 дүгээр тогтоолоор Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын нутагт орших Төвхөн хийдийн хамгаалалтын бүсийг; 2003 оны 190 дүгээр тогтоолоор Төв аймгийн нутагт орших Манзуширын хийд, Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших Дарь-Эхийн сүмийн 2 чулуун баганын хамгаалалтын бүсийг; 2004 оны 126 дугаар тогтоолоор Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших Баруун хүрээний туурь, Булган аймгийн Рашаант сумын нутагт орших Хөгнө тарнын дээд, доод хийдийн туурийн хамгаалалтын бүсийг; 2009 оны 135 дугаар тогтоолоор Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутагт орших Балдан Бэрээвэн хийд, түүний орчмын хадны зургийн дурсгалын хамгаалалтын бүсийг тус тус тогтоожээ.

⁴³ Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төслийн төгсгөлийн тайлан. Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яам, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Жайка). УБ., 2021, тал 84.

⁴⁴ Г.Анхсанаа, Г.Энхбат, А.Цоож. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. XII дэвгэр - Өмнөговь аймаг. Соёлын өвийн төв. УБ., 2019, тал 9.

Монголд хөгжсөн Бурханы шашин нь монголын ард түмний олон зуун жилийн оюуны өвийг тээж, хадгалж ирсэн учир Буддын өв соёлыг хадгалж хамгаалах, судлах, өвлөн эзэмших, улмаар өв соёлоороо бахархах үндэсний ухамсрыг бэхжүүлэх ажил нь Монгол Улсын соёл иргэншлийн аюулгүй байдалд холбогдох төрийн бодлогын чухал хэсэг юм. Тиймээс сүүлийн гучин жилд төрөөс түүний үнэ цэнийг үнэлж, соёл, соёлын өвийг хамгаалах талаар баримтлах бодлогодоо тусган анхаарч ирсэн. Цаашид ч энэ тал дээр илүү их хүчин чармайлт гаргаж, хөрөнгө хүч зарцуулах шаардлагатай юм.

Ном зүй

Архивын баримт, баримтын эмхэтгэл, нэг сэдэвт бүтээл

1. МУУТА, УТНОНБ-ын архив. Х-4, Д-6, ХН-92
2. Г.Анхсанаа, Г.Энхбат, А.Цоож. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. XII дэвтэр - Өмнөговь аймаг. Соёлын өвийн төв. УБ., 2019
3. О.Батсайхан, З.Лонжид, С.Баатар. Хэлмэгдэл ба Цагаатгал: түүх ба баримт. Хоёр дахь хэвлэл. УБ., 2021
4. О.Батсайхан, З.Лонжид ба бусад. Монголчууд нийгэмд журамд давшин орсон нь. (1924-1959). Хоёр дахь хэвлэл. УБ., 2017
5. Г.Лувсанцэрэн, Э.Ариунаа. Буддын уламжлалт мэдлэг ухааны үндэс. УБ., 2007
6. Н.Хатанбаатар. Монголын хүрээ хийд, лам нар. (XVI-XX зууны эхэн). УБ., 2018
7. Харнууд З.Лонжид. Түүх сөхөхүй. УБ., 2011
8. Ц.Цэрэнжанцан, Л.Ганбаатар, Д.Ганбаатар. Түүх соёлын дурсгалт барилга байгууламжийг сэргээн засварлах уламжлалт арга. УБ., 2006
9. Г.Энхбат, Б.Даваацэрэн. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. II дэвтэр - Сүхбаатар аймаг. Соёлын өвийн төв. УБ., 2011
10. Чойжин ламын сүм. Монголын уламжлалт архитектур 04. Монгол Улсын Соёлын Өвийн Үндэсний төв, Бүгд Найрамдах Солонгос Улсын Соёлын Өвийн Судалгааны Үндэсний хүрээлэн. УБ., 2018
11. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. Хоёрдугаар боть (1911-1926.V сар). Ерөнхий редактор Б.Чимид. УБ., 2010

Эрдэм шинжилгээний өгүүлэл, тайлан

1. Д.Нарантуяа. Монголын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалууд. “Соёлын өв” мэдээллийн сэтгүүл. №1. УБ., 2008
2. У.Сайнбаяр. Монголын ховор ном, судар дэлхийн баримтат өвийн жагсаалтад бүртгэгдлээ. “Соёлын өвийн мэдээ, мэдээлэл” сэтгүүл. 2011 оны 1/ №5. УБ., 2011
3. Ш.Сонинбаяр. Монголын түүх соёлын эрт эдүгээгийн гайхамшигт дурсгал Эрдэнэзуу хийд. Лам нарын сэтгүүл. 12 сар №3, УБ., 2010
4. Ш.Энхтуяа. Баримтат өвийн тухай. “Соёлын өвийн мэдээ, мэдээлэл” сэтгүүл (2011-2018). №8. УБ., 2011
5. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төслийн төгсгөлийн тайлан. Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яам, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Жайка). УБ., 2021
6. Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны үр дүнгийн гэрээний биелэлтийн нэгдсэн дэлгэрэнгүй тайлан. УБ., 2019
7. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллого (2018-2019 он). УБ., 2018

Цахим эх сурвалж

1. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: <https://www.1212.mn>

2. <http://unesco.mn> _
3. Соёлын өвийн сүлжээ, харилцаа холбооны зөвлөл: <https://barimtatuvmongoluv.mn>
4. ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс: <http://unesco.mn>
5. Дэлхийн өв – Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны вэйб сайт: <https://orkhonvalley.gov.mn> _
6. Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах конвенц (1972): <http://unesco.mn>
7. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn>
8. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн тоо баримт. СӨҮТ-ийн вэб хуудас дахь УНБМС-ийн танилцуулга: <https://ncch.gov.mn>
9. Монголын түүх, соёлын “хосгүй үнэт” дурсгалт зүйлийн жагсаалт. СӨҮТ-ийн Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээлэл: <http://ncch.gov.mn>
10. “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн төрөл зүйлийн үзүүлэлт”, СӨҮТ-ийн СӨУлсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээлэл: <https://ncch.gov.mn>
11. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр, Засгийн газрын 2007 оны 303 тоот тогтоолын хавсралт: <https://www.legalinfo.mn>

Abstract: *Buddhist culture has a special role in the cultural life of Mongolians. Buddhism has spread to Mongolia three times. During this time, a unique Mongolian culture was created, which has a large place in the cultural heritage of Mongolians. Therefore, the registration, preservation, protection, and study of Buddhist cultural heritage in Mongolia are an integral part of cultural heritage research in Mongolia.*

Research, reports, and data from professional cultural organizations provide information on the tangible cultural heritage of Buddhism in Mongolia, and its preservation and protection, but there are few studies that summarize them. Therefore, in this article, we have summarized the amount of the tangible cultural heritage of Buddhism registered in the Unified State Register of Cultural Heritage. Also, reviewed the government's policy on the value, restoration, preservation, and protection of Buddhist cultural heritage in Mongolia.